ДУНДГОВЬ АЙМАГ
**ЦАГААНДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2023 оны 05 сарын 01 өдөр Дугаар А/29 Хараат

"Уяхан замбуу тивийн наран"
3000 уртын дуучид, морин хуурчдын
эвент наадам зохион байгуулах
комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, "морин хуураа дээдлэн дэлгэрүүлэх турхай" Ерөнхийлөгчийн 2004 оны 134 дүгээр зарлиг, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2.6.3.4, 3.4.5, Дундговь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлин 1.2.1.2, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.5.3.3 дахь заалт, аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн А/150 дугаар захирамжийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Уяхан замбуу тивийн наран" 3000 уртын дуучид, морин хуурчдын эвент наадамд оролцох комиссын бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Монгол ардын уртын дуу "Уяхан замбуу тивийн наран", "Энх мэндийн баяр", "Оломгү далай", морин хуурын ачлгуу "Дундговийн магтаал", "Миний нутгийн бараа", "Төв Халх жонон" зэрэг уран бүтээлүүдийг нийт иргэддээ заах сургах ажлыг өрнүүлэн, хуурчдыг морин хуур хөгжмөөр хангахад санаачилга гарган ажиллахыг албан байгууллага, аж ахуй нэгжийн удирдлагуудад үүрэг болгосугай.

3. "Уяхан замбуу тивийн наран" 3000 уртын дуучид, морин хуурчдын эвент наадмын бэлтгэл ажлыг ханган гүйцэтгэх ажлын чиг үүргийг тодорхойлж, төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, үр дүнтэй зохион байгуулахыг комиссын дарга (Н.Батгэрэл)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА А.ЭРДЭНЭСАЙХАН

Сумын Засаг даргын 2023 оны 05 дугаар
сарын 01 –ний өдрийн 01/29 дугаар
захирамжийн хавсралт

“УЯХАН ЗАМБУУ ТИВИЙН НАРАН”
3000 УРТЫН ДУУЧИД, МОРИН ХУУРЧДЫН ЭВЕНТ НААДАМ
ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Комиссын дарга: -Н.Батгэрэл (Засаг даргын орлогч)

Нарийн бичгийн дарга: -Б.Алдармаа (Соёлын төвийн дарга)

Гишүүд: -Б.Цэрэнмаа (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

-Г.Жаргалмаа (1 дүгээр багийн Засаг дарга)

- Э.Баярмаа (2 дугаар багийн Засаг дарга)

- Ц.Ундрахбаяр (3 дугаар багийн Засаг дарга)

-Б.Балжинням (4 дүгээр багийн Засаг дарга)

-Д.Сарантуяа (Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч)

-П.Очирхүү (Эрүүл мэндийн төвийн дарга)

-У.Мөнх-Эрдэнэ (Ерөнхий боловсролын сургуулийн захирал)

-Идэрцэцэг (Соёлын төвийн хөгжмийн багш)

-Ж.Чулуунбат (Соёлын төвийн бүжгийн багш)